

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Албан шаардлага	
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав бас Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.24 № 2/22
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орлого үр дүнгийн тайланд орлого дутуу тусгасан, тайлант үеийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн, засаг даргын захирамжийн биелэлт хангалтгүй, насжилт өндөртэй авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төсвийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, жилийн эцэст тооллого хийж тооцоо бодож баталгаажуулаагүй, ХХОАТ-ын тайлан гаргалт хангалтгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "толилуулга", "эрх ба үүрэг", "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төгрөгөөр

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,258,409,436	1,923,122,343
33	АВЛАГА	483,391,315	1,340,200,485
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,100,000	-
335	Бусад авлага	482,291,315	1,340,200,485
3351	Байгууллагаас авах авлага	482,291,315	1,340,200,485
34	УРЬДЧИЛГАА	379,933,578	74,458,278
34600	Урьдчилж гарсан зардал	378,159,478	74,058,278
3471	Урьдчилгаа тооцоо	1,774,100	400,000
34713	Цалингийн урьдчилгаа	1,774,100	400,000
35	БАРАА МАТЕРИАЛ	165,823,873	223,285,451
354	Хангамжийн материал	143,503,994	181,700,750
35410	Бичиг хэргийн материал	2,913,000	2,860,900
35420	Аж ахуйн материал	954,000	393,000
35430	Сэлбэг хэрэгсэл	14,820,712	16,612,750
35450	Барилгын засварын материал	52,363,300	77,566,450
35470	Бусад хангамжийн материал	72,452,982	84,267,650
35600	Мал амьтад	22,319,879	41,584,701
36	НӨӨЦИЙН БАРАА	229,260,670	285,178,130
36100	Барааны нөөц	170,388,470	261,774,730
36300	Тэжээлийн нөөц	58,872,200	23,403,400
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,021,313,539	4,232,529,752
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,021,313,539	4,232,529,752
391	Газар		
392	Биет хөрөнгө	3,309,142,939	3,491,548,151
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,135,105,091	3,307,587,127
39202	Хуримтлагдсан элэгдэл	(243,185,250)	(356,925,934)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	510,624,024	544,724,024
39204	Хуримтлагдсан элэгдэл	(400,984,304)	(448,645,090)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	388,059,013	515,342,944
39206	Хуримтлагдсан элэгдэл	(305,602,655)	(273,170,874)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	279,074,598	235,021,698
39208	Хуримтлагдсан элэгдэл	(209,056,346)	(184,124,936)
39209	Зам, гүүрийн байгууламж	253,736,906	254,528,906

39210	Хуримтлагдсан элэгдэл	(109,585,710)	(128,582,372)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	12,189,700	29,289,700
39212	Хуримтлагдсан элэгдэл	(1,232,128)	(3,497,042)
393	Биет бус хөрөнгө	712,170,600	740,981,600
39301	Програм хангамж	17,886,115	17,886,115
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,515,115)	(16,972,115)
39303	Бусад биет бус хөрөнгө	710,799,600	740,067,600
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,279,722,975	6,155,652,095
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,279,722,975	6,155,652,095
51	Засгийн газрын хувь оролцоо	5,279,722,975	6,155,652,095
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,829,163,598	2,858,431,598
51101	Өмч: - төрийн	2,829,163,598	2,858,431,598
512	Хуримтлагдсан үр дүн	1,292,622,550	2,147,336,210
51210	Өмнөх үеийн үр дүн	1,292,622,550	1,289,183,212
51220	Тайлант үеийн үр дүн	-	858,152,997
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,157,936,827	1,149,884,288
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,279,722,975	6,155,652,095

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,839,788,766	5,717,349,717
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	397,051,935	231,243,366
120	Нийтлэг татварын бус орлого	397,051,935	231,243,366
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	397,051,935	231,243,366
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,406,578	27,785,900
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	381,645,357	203,457,466
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,442,736,831	5,486,106,351
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,398,784,031	2,253,583,651
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,645,830	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	912,212,253	667,276,340
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	364,675,248	1,525,186,011

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,250,700	61,121,300
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,043,952,800	3,232,522,700
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,043,952,800	3,232,522,700
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,978,058,100	4,859,196,720
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,978,058,100	4,859,196,720
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,842,276,822	4,778,706,138
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	994,859,308	981,729,908
210101	Үндсэн цалин	470,167,916	439,195,877
210102	Нэмэгдэл	218,616,784	302,033,783
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,452,900	12,849,617
210105	Гэрээт ажлын хөлс	290,621,708	227,650,631
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,626,900	129,001,824
210201	Тэтгэврийн даатгал	93,219,400	90,917,203
210202	Тэтгэмжийн даатгал	9,068,800	9,126,969
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,681,600	7,261,295
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,400	1,812,996
210205	Эрүүл мэндийн даатгал	17,736,700	19,883,362
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,387,326	222,965,067
210301	Гэрэл, цахилгаан	44,920,268	40,904,406
210302	Түлш, халаалт	179,239,498	166,905,245
210303	Цэвэр, бохир ус	23,227,560	15,155,416
2104	Хангамж, бараа материалын зардал	143,806,817	122,240,745
210401	Бичиг хэрэг	21,186,315	21,879,110
210402	Тээвэр, шатахуун	68,980,691	86,337,534
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,716,079	11,512,841
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	591,300	435,800
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	716,800	2,075,460
210408	Бараа материал актальсны зардал	36,222,632	-
2105	Нормативт зардал	2,821,400	2,635,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,821,400	2,635,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,327,960	15,044,996
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,459,500	54,760
210604	Урсгал засвар	19,868,460	14,990,236
2107	Томилолт, зочны зардал	15,214,900	16,487,300
210702	Дотоод албан томилолт	15,214,900	16,487,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	511,701,467	345,642,857

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	503,731,184	338,155,353
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,078,000	1,500,000
210803	Даатгалын үйлчилгээ	2,759,190	1,492,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,204,213	1,755,377
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000	201,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,633,480	2,238,925
210807	Газрын төлбөр	1,045,400	300,202
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,773,530,744	2,942,958,442
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,540,904,465	2,700,405,989
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,723,146	1,468,620
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	230,903,133	241,083,833
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,781,278	80,490,582
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,461,000	77,860,600
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,693,000	58,772,252
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,768,000	19,088,348
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	320,278	2,629,982
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,278	2,629,982
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(138,269,334)	858,152,997
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	95,354,167	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	95,354,167	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(95,354,167)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(233,623,500)	858,152,997

.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,829,163,598	1,157,936,827	1,292,622,550	5,279,722,975
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598	1,157,936,827	1,292,622,550	5,279,722,975
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598	1,157,936,827	1,292,622,550	5,279,722,975
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,829,163,598	1,157,936,827	1,292,622,550	5,279,722,975
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,439,338)	(3,439,338)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598	1,157,936,827	1,289,183,212	5,276,283,637
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(8,052,539)	-	(8,052,539)

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	29,268,000	-	-	29,268,000
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	858,152,997	858,152,997
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,858,431,598	1,149,884,288	2,147,336,210	6,155,652,095

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,116,593,719	5,717,349,717
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,424,078	27,785,900
120	Нийтлэг татварын бус орлого	15,424,078	27,785,900
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,424,078	27,785,900
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,424,078	27,785,900
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,101,169,641	5,689,563,817
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,057,216,841	2,457,041,117
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,645,830	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	912,212,253	699,913,273
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	364,675,248	1,757,127,844
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	679,683,510	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,043,952,800	3,232,522,700
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,043,952,800	3,232,522,700
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,116,593,719	5,717,349,717
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,116,593,719	5,717,349,717
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,743,678,265	4,431,781,105
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	994,859,308	981,729,908
210101	Үндсэн цалин	470,167,916	439,195,877
210102	Нэмэгдэл	218,616,784	302,033,783
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,452,900	12,849,617
210105	Гэрээт ажлын хөлс	290,621,708	227,650,631
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,626,900	129,001,824
210201	Тэтгэврийн даатгал	93,219,400	90,917,203
210202	Тэтгэмжийн даатгал	9,068,800	9,126,969
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,681,600	7,261,295
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,400	1,812,996
210205	Эрүүл мэндийн даатгал	17,736,700	19,883,362

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,677,100	253,588,900
210301	Гэрэл, цахилгаан	47,030,300	50,185,000
210302	Түлш, халаалт	180,789,500	180,786,074
210303	Цэвэр, бохир ус	26,857,300	22,617,826
2104	Хангамж, бараа материалын зардал	119,843,900	90,116,800
210401	Бичиг хэрэг	20,053,200	15,068,700
210402	Тээвэр, шатахуун	73,511,600	53,989,825
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,343,400	14,269,365
210404	Ном, хэвлэл	1,441,900	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000	700,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,653,800	6,088,910
2105	Нормативт зардал	2,720,000	3,083,300
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,720,000	3,083,300
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,852,400	16,685,243
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,356,900	3,779,520
210604	Урсгал засвар	37,495,500	12,905,723
2107	Томилолт, зочны зардал	16,216,800	22,724,500
210702	Дотоод албан томилолт	16,216,800	22,724,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	563,824,599	120,333,343
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	552,691,699	108,684,486
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000	1,500,000
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000	2,333,300
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,237,500	1,031,200
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000	208,300
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000	5,735,325
210807	Газрын төлбөр	1,045,400	840,732
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,615,057,258	2,814,517,287
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,611,057,258	2,811,305,662
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000	3,211,625
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	372,915,454	1,285,568,612
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,693,000	77,860,600
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,693,000	58,772,252
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000	19,088,348
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	237,222,454	1,207,708,012
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	237,222,454	1,207,708,012
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,272,522,700	3,247,559,058
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,272,522,700	3,247,559,058
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,207,917,100	3,169,698,458
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	963,497,000	963,384,606
210101	Үндсэн цалин	505,543,200	439,195,877
210102	Нэмэгдэл	219,425,200	302,033,783
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,452,900	12,849,617
210105	Гэрээт ажлын хөлс	223,075,700	209,305,329
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,072,100	129,001,824
210201	Тэтгэврийн даатгал	91,532,200	90,917,203
210202	Тэтгэмжийн даатгал	9,635,000	9,126,969
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,708,000	7,261,295
210204	Ажилгүйдлийн даатгал	1,927,000	1,812,996
210205	Эрүүл мэндийн даатгал	19,269,900	19,883,362
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	289,921,900	253,588,900
210301	Гэрэл, цахилгаан	50,185,000	50,185,000
210302	Түлш, халаалт	211,383,900	180,786,074
210303	Цэвэр, бохир ус	28,353,000	22,617,826
2104	Хангамж, бараа материалын зардал	84,116,800	90,116,800
210401	Бичиг хэрэг	11,568,700	15,068,700
210402	Тээвэр, шатахуун	53,674,400	53,989,825
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,286,200	14,269,365
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000	700,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,887,500	6,088,910
2105	Нормативт зардал	3,083,300	3,083,300
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,083,300	3,083,300
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,083,400	16,685,243
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,416,700	3,779,520
210604	Урсгал засвар	18,666,700	12,905,723
2107	Томилолт, зочны зардал	33,477,900	22,724,500

210702	Дотоод албан томилолт	33,477,900	22,724,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,324,000	39,945,557
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,296,700	28,296,700
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000	1,500,000
210803	Даатгалын үйлчилгээ	2,333,300	2,333,300
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,031,200	1,031,200
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	208,300	208,300
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,083,300	5,735,325
210807	Газрын төлбөр	871,200	840,732
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,643,340,700	1,651,167,728
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,640,007,400	1,647,956,103
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,333,300	3,211,625
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,605,600	77,860,600
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,605,600	77,860,600
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,772,300	58,772,252
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,833,300	19,088,348
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,272,522,700	3,247,559,058
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,252,522,700	3,229,892,718
132001	Орон нутгийн төсвөөс	3,252,522,700	3,229,892,718
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000	17,666,340
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000	17,666,340
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,637,254,516	1,254,309,305
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,637,254,516	1,254,309,305
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,637,254,516	1,254,309,305
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,345,200	18,345,302
210105	Гэрээт ажлын хөлс	19,345,200	18,345,302
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	310,560,200	115,231,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	310,560,200	115,231,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,307,349,116	1,120,733,003
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,307,349,116	1,120,733,003

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,637,254,516	1,254,309,305
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,637,254,516	1,254,309,305
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	875,632,500	699,913,273
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	761,622,016	554,396,032
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд касс, хөрөнгө, бараа материалын зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 2/156 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн ЗДТГазар нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан, хүний хөгжлийг ханган, төрийн албыг чадавхжуулж, иргэд, үйлдвэрлэл бизнест ээлтэй, ногоон хөгжлийн **АЙМАГ** болохын төлөө нутгийн захиргааны байгууллагуудыг манлайлан ажиллана гэсэн зорилт тавин ажилласан байна. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, сайн засаглалыг бэхжүүлэх
- ✓ Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн цогц үйлчилгээг зорилтод бүлгүүдэд шуурхай хүргэх

- ✓ *Үйлдвэрлэл, бизнест ээлтэй орчин бүрдүүлсэн эдийн засгийн өсөлтийг дэмжиж орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг бий болгох*
- ✓ *Хүн амьдрах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгаа хамгаалах, зүй зохистой ашиглах замаар ногоон хөгжлийн загвар хот болох*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөндлөнгийн байгууллагын дотоод хяналт шалгалт 2021 онд байгууллагын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 4628.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 46.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 37.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 875.9 сая төгрөгөөр буюу 30% хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 508.5 сая төгрөг болж 113.4 сая төгрөгөөр өссөн нь бараа хангамжийн материал 57.5 сая, нөөцийн бараа 55.9 сая төгрөгөөр шинэчилсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 926.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 129.3 сая төгрөгөөр бэлтгэж нийт 1056.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 942.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын дансанд оны эхэнд байгууллагаас авах авлага 482.3 сая, төлбөртэй үйлчилгээний 1.1 сая, урьдчилж гарсан зардлын үлдэгдэл оны эхэнд 378.1 сая, цалингийн урьдчилгаа 1.8 сая төгрөг байснаас оны эцэст байгууллагаас авах авлага 1340.2 сая төгрөг болж 857.9 сая төгрөгөөр өссөн, урьдчилж гарсан зардлын авлагын үлдэгдэл 304.1 сая төгрөгөөр буурч 74.0 сая төгрөг, цалингийн урьдчилгаа 1.4 сая төгрөгөөр буурч 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 4021.3 сая төгрөг байсан бол оны эцэст 4232.5 сая төгрөг болж 211.2 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө худалдаж авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 4021.3 сая төгрөг байсан бол оны эцэст 4232.5 сая төгрөг болж 211.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 176.4 сая төгрөгийн хөрөнгө тогтоол шийдвэргүй бэлтгэж, үнэ төлбөргүй 74.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч барилгын их засварын зардал болох 172.5 сая төгрөгийн хөрөнгө капиталжуулж, Мянган Угалзат ОНӨҮГ-аас 20.3 сая төгрөг, Ахмадын хорооны 9.0 сая төгрөгийн газар шилжүүлэн авч засгийн газрын санг нэмэгдүүлж ИТХ-ын 2021 оны 12-р сарын 30-ны 183 тоот тогтоолоор 70.7 сая төгрөгийн хөрөнгө акталж шийдвэргүй 44.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна. Тайлант оны эцэст 4232.5 сая төгрөгийн цэвэр хөрөнгийн үлэгдэлтэй байна

Тайлант оны эхэнд өр тайлагнаагүй, тайланд оны хугацаанд үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулж оны эцэст тайланд өр төлбөр тусгагдаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2829.1 сая, тайлант оны эцэст 2858.4 сая төгрөг болж үнэ төлбөргүй шилжүүлж ирсэн газар болох 29.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнг 3.4 сая төгрөгийн бууруулсан бичилт хийсэн. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2147.3 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3252.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс тус байгууллагын төсвийн орлогыг 3232.5 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 20.0 сая төгрөгөөр, зардлыг 3252.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3252.5 сая төгрөгийн төсөв баталснаас 3232.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 20.0 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 3232.5 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны орлогоос 27.3 сая төгрөг, нийт 3259.8 сая төгрөгийн орлого олж 3247.6 сая төгрөгийн зардал гарган 12.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3247.6 сая төгрөг буюу 98 хувь зарцуулсан нь үйл ажиллагааны орлогоос олсон 2.6 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, түрээсийн орлогын 40%-ийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлангаар БОАЖЯ-аас агаарын бохирдлын санхүүжилт 810.0 сая, ОНХС-аас 298.7 сая, ОНХО-аас 92.5 сая Засаг даргын нөөц хөрөнгөөр 318.3 сая, УТХО-аас автомашины санхүүжилт 192.0 сая, төсөл хөтөлбөрөөс 7.1 сая, ХО-ын барьцаа хөрөнгө данснаас 140.4 сая, ХО-ын ТХЗ-ын данснаас 79.1 сая, Хөшөөт хөгжил сангаас 3.6 сая, өвсний үнэ 134.3 сая, Архивын ерөнхий газрын санхүүжилт 18.3 сая, Засаг дарга данснаас 82.6 сая, бусад орлогоос 76.7 сая, өмнөх оны үлдэгдлээс 238.4 сая төгрөг нийт 2492.0 сая төгрөг оруулж, 1254.3 сая төгрөг зарцуулж 1237.7 сая төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсноор тус байгууллагад анхаарал татахуйц онцлог ажил гүйлгээ нь ковид-19 цар тахалтай холбоотой эргэн төлөгдөх нөхцөлтэй 485.9 сая төгрөгийн мах, хүнс, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийн борлуулалт хийсэн байна.

Мөн ковид-19 цар тахалтай холбоотой 1206.1 сая төгрөгийн гамшгаас хамгаалах зардал гарсан байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсноор Засаг даргын захирамжийн биелэлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт хангалтгүй, насжилт өндөртэй авлага бууруулаагүй өмнөх онуудын нөөцийн мах, өвсний тооцоо хангалтгүй, хөрөнгөнд бүртгэлтэй прусс маркийн автомашин биетээр байхгүй хөрөнгө шилжүүлэх шийдвэр гараагүй байхад ЭМДХ-т ашиглагдаж хөрөнгийн үр ашиг буурсан нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд үлэмж нөлөө үзүүлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 135 мэдээлэл хугацаандаа оруулсан 12 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн, 4 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар захиргааны хуулийн 103-тай холбоотой 79.2 сая төгрөг, авлага бууруулж ажиллах, төсвийн үргүй зардал гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийн хувь 70%-тай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь Засаг даргын захирамжийн хэрэгжилт, нөөц хөрөнгө, цар тахалтай холбоотой гарсан зардлын зарцуулалт, үндсэн хөрөнгө, бараа материалын ангилалт, өмч хамгаалах комиссын дотоод хяналтын хэрэгжүүлсэн ажил, шатахуун зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1502.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11.2 сая төгрөгийн төлбөрийн 3 зөрчилд 2 төлбөрийн акт, төсвийн зарцуулалттай холбоотой 469.6 сая төгрөгийн 4 зөрчилд 2 албан шаардлага, 715.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч 306.3 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлээ.

4.1 Залруулсан алдаа

1.1 Орлого, үр дүнтэй холбоотой

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Илрүүлэлт: Үр дүнд орлого дутуу 306.3 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд орлого илүү 7.0 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлан 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, жинхэнэ зарлага үр дүн 17.8 сая төгрөг зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 306.3 сая төгрөгийн алдааг 2022 оны 03 дугаар сарын 25-ны 2/504 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.2.1 Төсвийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн, НДШ-ийн тооцоо зөрүүтэй, хүн амын орлогын албан татвар суутгаж аваад төсөвт төлөөгүй 5.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Цалингаас суутгасан ашгийн татвар төлөөгүй 5.5 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

4.2.2 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэргийн хэлтсийн ажилчдын онцгой нэмэгдлийг журмын дагуу олгоогүй 4.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 9-р зүйлийн 9.2.3 дахь заалт, Засгийн газрын 2004 оны 05-р сарын 26-ны 123 тоот тогтоол "Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам" -ын 3 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Цалингийн нэмэгдэл журмын дагуу олгоогүй 4.5 сая төгрөгийг нэр бүхий хүмүүст буцаан олгох төлбөрийн акт тогтоох

4.2.3 Түрээсийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн орлогын 40%-ийг бүрэн төвлөрүүлээгүй 960.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02-р сарын 18-ны 49 тоот тогтоолын 2 дугаар заалт, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн 960.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

4.3.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Захирамжийн биелэлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт хангалтгүй 207.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн үргүй зардал гаргаж зориулалт бус зарцуулахыг таслан зогсоох албан шаардлага бичлээ.

4.3.2 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Насжилт өндөртэй авлага бууруулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, өмнөх онуудын нөөцийн мах, өвсний тооцоо хангалтгүй хийгдсэн 213.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж насжилт өндөртэй авлага бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага бичлээ.

4.3.3 Түрээсийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын албан өрөөг төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагууд түрээсэлж байгаа албан өрөөний түрээсийн төлбөрөө бүрэн төлөөгүй, орон сууцны ашиглалтын гэрээ байхгүй шаардлагатай албан тушаалтныг байраар хангаагүй 30.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02-р сарын 18-ны 49 тоот тогтоолын 1 дүгээр заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах,

Шийдвэрлэлт: ЗДТГ-т бүртгэлтэй орон сууц, албан өрөө түрээсэлж байгаа байгууллагуудтай хөрөнгө ашиглалтын гэрээ шинэчлэн хийж төсвийн орлого нэмэгдүүлэх албан шаардлага бичлээ.

4.3.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй прусс маркийн автомашин биетээр байхгүй хөрөнгө шилжүүлэх шийдвэр гараагүй байхад ЭМДХ-т ашиглагдаж хөрөнгийн үр ашиг буурсан 17.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д

"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдгийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

4.4.1 Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардлын тооцоог норм нормативаар нь бодоогүй, хот дотор явж байгаа шатахууны зардал хэмнэгдээгүй, машин унах эрх бүхий албан тушаалтны жишиг норм баримтлаагүй, дотоод хяналт сул зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 тоот тогтоол "суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажаагүй гүйлгээ хийхгүй байх, шатахуун зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах

4.4.2 Төсвийн хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43-р тогтоолоор төсвийн хэмнэлт гаргаж 10-аас доошгүй хувийг төсөвт төвлөрүүлээгүй 320.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2021/02/17-ны 43 тоот "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3, 1.6, 1.8, 1.9 дэх заалтууд" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах

4.4.3 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчдийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй кассаар их хэмжээний мөнгө зарцуулаад мөнгөн кассын журам баримтлаагүй 218.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоорондын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, мөнгөн кассын журмыг баримталж ажиллах

4.4.4 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдээдгийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу ангилж бүртгээгүй шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн 176.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийж өмч хамгаалах зөвлөлийн тайланг удирдах зөвлөлөөр хэлэлцэх, хөрөнгө шийдвэргүй бэлтгэхгүй байх, хөрөнгийн ангиллыг стандартын дагуу хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ЗДТГ	9	1530.8	1	334.4	2	11.2	2	469.6	4	715.5

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР